



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 4/19

Мандалговь

“Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй”
байдлыг хангахад бэлтгэл бэлэн байдал
хангах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Аргачлал зардлын норматив батлах тухай” А/23, 27 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын 102 жил, Дундговь аймаг байгуулагдсаны 81 жилийн ойн баяр наадмын хурдан морины уралдааны уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллахад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг бэлтгэсүгэй.
2. Шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.
3. Хэрэглэгдэхүүнд шаардагдах 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хяналт - шинжилгээ, үнэлгээ, мэдээлийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Намуунзул)-д үүрэг болгосугай.
5. Хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хяналт - шинжилгээ, үнэлгээ, мэдээлийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Намуунзул)-д даалгасугай

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

48730103

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 09 ны өдрийн
11/9 дугаар тушаалын 1. дүгээр хавсралт

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД
БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Майхан	Метр	4:6	4,000,000

---oOo---